

# ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2024/42/НА-СТА-ТӨА

Цахим хуудас: [www.audit.mn](#)  
Улаанбаатар хот  
2024 он

Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал,  
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг  
Утас: 261665 Цахим хаяг: [naranchimegts@audit.gov.mn](#)

Аудитын менежер: С.Нацагдорж  
Утас: 261885 Цахим хаяг: [natsagdorjs@audit.gov.mn](#)

Ахлах аудитор: Б.Эрдэнэзул  
Утас: 261729 Цахим хаяг: [erdenezulb@audit.gov.mn](#)

Аудитор: М.Лхагвасүрэн  
Утас: 261729 Цахим хаяг: [lkhaqvasurenm@audit.gov.mn](#)

Шинэ баланс Аудит ХХК-ийн захирал: Б.Мэндбаяр  
Утас: 99032649 Цахим хаяг: [info@shinebalans-audit.mn](#)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

2024.03.25 № 07/787  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Г "МОНГОЛ ГАЗРЫН ТОС  
БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР" ТӨХХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Д.АЛТАНЦЭЦЭГ  
ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Аудитын гол асуудал

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинд үндсэн үйл ажиллагааны орлогоос 750.4 сая төгрөг, бусад орлогоос 0.6 сая төгрөгийн орлого бүрдүүлж, валютын ханшийн зөрүүний олз 5,646.9 төгрөгийг хүлээн зөвшөөрч, борлуулсан бүтээгдэхүүний өртөгт 1,250.5 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны зардалд 7,996.4 сая төгрөг, үндсэн бус үйл ажиллагааны зардалд 9,497.4 сая төгрөгийг зарцуулж, 12,346.4 сая төгрөгийн алдагдалтай төлөвлөсөн байна.

Хөгжлийн банкны 347,582.6 сая төгрөгийн зээлийн эх үүсвэрээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 342,599.3 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр 664.1 сая төгрөгийн орлого бүрдүүлж, гадаад валютын ханшийн 15,688.2 сая төгрөгийн олз хүлээн зөвшөөрч, нийт 16,917.9 сая төгрөгийг зарцуулж, 918.5 сая төгрөгийн хойшлогдсон татвар тооцож, 1,484.1 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 292,998.5 сая төгрөгийг зарцуулж, 85.5 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь дамжуулах хоолойн зураг төслийг хянан баталгаажуулах

"Захиалагчийн инженер"-ийн зөвлөх үйлчилгээний ажлын гүйцэтгэгч гүйцэтгэлийн баталгаа ирүүлээгүйгээс шалтгаалан биелэлт дутуу хэрэгжсэн байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Тайлант онд нийт 20 удирдах, 101 гүйцэтгэх, нийт 121 ажилтны орон тоо батлагдсанаас удирдах албан тушаалд 20, гүйцэтгэх албан тушаалд 76 ажилтан ажиллаж, 25 орон тоо хэмнэж ажилласан байна.

Компанийн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд 8 зорилтын хүрээнд 101 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн, биелэлт 75.0 хувьтай гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц НАРАНЧИМЭГ



## Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12 сарын 31	2023 оны 12 сарын 31
1.1.01	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	2,150,129,083.29	2,966,920,880.95
1.1.02	Дансны авлага	34,238,973.18	97,599,059.05
1.1.03	Татвар, НДШ-ийн авлага	414,077,405.11	1,076,057,768.96
1.1.04	Бусад авлага	47,520,000.00	49,405,983.03
1.1.06	Бараа материал	47,019,349.97	72,177,281.80
1.1.07	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	4,182,311,221.04	109,041,173,994.65
<b>1.1.11</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>6,875,296,032.59</b>	<b>113,303,334,968.44</b>
1.2.01	Үндсэн хөрөнгө	235,164,463,723.31	500,405,094,732.37
1.2.02	Биет бус хөрөнгө	9,532,588,442.53	9,512,990,500.26
1.2.04	Урт хугацаат хөрөнгө оруулалт	1,000,000.00	-
1.2.06	Хойшлогдсон татварын хөрөнгө	612,736,883.16	-
<b>1.2.10</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>245,310,789,049.00</b>	<b>509,918,085,232.63</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>252,186,085,081.59</b>	<b>623,221,420,201.07</b>
2.1.1.01	Дансны өглөг	-	15,172,512,741.95
2.1.1.02	Цалингийн өглөг	67,110.92	121,172.56
2.1.1.03	Татварын өр	71,834,181.49	17,066,950.00
2.1.1.04	НДШ - ийн өглөг	71,186,099.96	-
2.1.1.08	Урьдчилж орсон орлого	24,600,000.00	-
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	32,187,878.00	45,954,913,887.51
<b>2.1.1.13</b>	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>199,875,270.37</b>	<b>61,144,614,752.02</b>
2.1.2.01	Урт хугацаат зээл	166,335,840,254.32	176,729,650,692.32
2.1.2.02	Ур хугацаат зээлийн хүү	62,792,827,282.59	84,340,940,682.53
2.1.2.04	Бусад урт хугацаат өр төлбөр	65,843,956,920.61	345,476,744,857.45
<b>2.1.2.06</b>	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>294,972,624,457.52</b>	<b>606,547,336,232.30</b>
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>295,172,499,727.89</b>	<b>667,691,950,984.32</b>
2.3.01	Өмч: - төрийн	10,000,000.00	10,000,000.00
2.3.08	Эздийн өмчийн бусад хэсэг	9,384,783,200.00	9,384,783,200.00
<b>2.3.09</b>	<b>Хуримтлагдсан ашиг</b>	<b>(52,381,197,846.30)</b>	<b>(53,865,313,983.25)</b>
2.3.09.1	Тайлангийн үеийн ашиг	-	(1,484,116,136.95)
2.3.09.2	Өмнөх үеийн ашиг	(52,381,197,846.30)	(52,381,197,846.30)
<b>2.3.11</b>	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>(42,986,414,646.30)</b>	<b>(44,470,530,783.25)</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>252,186,085,081.59</b>	<b>623,221,420,201.07</b>

## 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12 сарын 31	2023 оны 12 сарын 31
01	Борлуулалтын орлого (цэвэр)	176,546,580.00	660,616,982.36
02	Борлуулалтын өртөг	62,231,172.55	877,272,181.41
03	Нийт ашиг (алдагдал)	114,315,407.45	(216,655,199.05)
08	Бусад орлого	617,036.34	3,467,028.30
10	Ерөнхий ба удирдлагын зардал	(7,543,372,076.04)	(7,430,826,492.41)
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	3,061,881.52	15,688,216,143.84
17	Бусад алдагдал	(3,499,176,396.49)	(8,609,801,923.28)
<b>18</b>	<b>Татвар төлөхийн өмнөх алдагдал</b>	<b>(10,924,554,147.22)</b>	<b>(565,600,442.60)</b>
19	Орлогын татварын зардал	-	(918,515,694.35)
20	Татварын дараах алдагдал	(10,924,554,147.22)	(1,484,116,136.95)
<b>22</b>	<b>Тайлант үеийн цэвэр алдагдал</b>	<b>(10,924,554,147.22)</b>	<b>(1,484,116,136.95)</b>

## 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Хөр-н дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
01	2021 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	10,000,000.00	9,384,783,200.00	-	(41,456,643,699.08)	(32,061,860,499.08)
02	НББ-ийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	(9,384,783,200.00)	9,384,783,200.00	-	-
03	Тайлант үеийн цэвэр алдагдал	-	-	-	(10,924,554,147.22)	(10,924,554,147.22)
09	2022 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	10,000,000.00	-	9,384,783,200.00	(52,381,197,846.30)	(42,986,414,646.30)
12	Тайлант үеийн цэвэр алдагдал	-	-	-	(1,484,116,136.95)	(1,484,116,136.95)
17	2023 оны 12 сарын 31-р үлдэгдэл	10,000,000.00	-	9,384,783,200.00	(53,865,313,983.25)	(44,470,530,783.25)

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12 сарын 31	2023 оны 12 сарын 31
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>1.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>161,540,515.52</b>	<b>497,322,299.78</b>
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээний орлого	132,551,238.00	465,530,136.60
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	203,400.00	445,000.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	28,785,877.52	31,347,163.18
<b>1.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>6,981,916,170.63</b>	<b>5,025,950,067.12</b>
1.2.1	Ажиллагчдад төлсөн	2,205,547,198.82	2,207,647,557.16
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	564,421,446.71	780,882,671.68
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	132,033,192.00	57,041,360.95
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	854,207,704.55	748,312,788.14
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	30,250,000.00	40,950,750.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	302,058,417.35	482,526,959.85
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	7,333,238.52	22,509,051.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	2,886,064,972.68	686,078,928.34
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(6,820,375,655.11)</b>	<b>(4,528,627,767.34)</b>
<b>2</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>2.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>3,469,865,398.00</b>	<b>5,048,390,873.00</b>
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	179,400,600.00	-
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	9,900,000.00	-
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	3,280,564,798.00	5,048,390,873.00
<b>2.3</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(3,469,865,398.00)</b>	<b>(5,048,390,873.00)</b>
<b>3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>3.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>7,590,995,543.62</b>	<b>10,393,810,438.00</b>
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	7,590,995,543.62	10,393,810,438.00
<b>3.3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>7,590,995,543.62</b>	<b>10,393,810,438.00</b>
<b>4</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(2,699,245,509.49)</b>	<b>816,791,797.66</b>
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>4,849,374,592.78</b>	<b>2,150,129,083.29</b>
<b>6</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>2,150,129,083.29</b>	<b>2,966,920,880.95</b>

## 2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/Мянган төгрөгөөр/

Д/д	Үзүүлэлтүүд	Х/н	2022 оны гүйцэтгэл	2023 оны		Зөрүү	Хувь
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	<b>НИЙТ ЭХ ҮҮСВЭР</b>	мян.төг	<b>7,705,928.0</b>	<b>347,083,160.0</b>	<b>297,007,979.0</b>	<b>(50,075,181.0)</b>	<b>85.6</b>
	<b>Нийт ашиг/алдагдал</b>	мян.төг	<b>114,315.0</b>	<b>(500,025.0)</b>	<b>(216,655.0)</b>	<b>283,370.0</b>	<b>43.3</b>
	Борлуулсан ажил, үйлчилгээний орлого	мян.төг	176,547.0	750,432.0	660,617.0	(89,815.0)	88.0
	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	мян.төг	62,231.0	1,250,456.0	877,272.0	(373,184.0)	70.2
	<b>Үйл ажиллагааны бус орлого</b>	мян.төг	<b>617.0</b>	<b>560.0</b>	<b>3,467.0</b>	<b>2,907.0</b>	<b>619.1</b>
	<b>Зээлээр санхүүжих</b>	мян.төг	<b>7,590,996.0</b>	<b>347,582,625.0</b>	<b>297,221,167.0</b>	<b>(50,361,458.0)</b>	<b>85.5</b>
2	<b>Нийт зардал</b>	мян.төг	<b>7,543,372.0</b>	<b>7,996,378.0</b>	<b>7,430,826.0</b>	<b>(565,552.0)</b>	<b>92.9</b>
	Ерөнхий ба удирдлагын зардал	мян.төг	3,998,895.0	4,483,260.0	4,006,036.0	(477,224.0)	89.4
	Элэгдлийн зардал	мян.төг	3,544,477.0	3,513,117.0	3,424,790.0	(88,327.0)	97.5
	ГВХЗ-ний олз	мян.төг	3,062.0	5,646,876.0	15,688,216.0	10,041,340.0	229.7
	<b>Үйл ажиллагааны бус зардал</b>	мян.төг	<b>3,499,176.0</b>	<b>9,497,438.0</b>	<b>8,609,802.0</b>	<b>(887,636.0)</b>	<b>90.7</b>
	Үйл ажиллагааны бус зардал	мян.төг	55,323.0	157,232.0	154,520.0	(2,712.0)	98.3
3	ГВХЗ-ний бодит бус гарз	мян.төг	3,443,853.0	9,340,206.0	8,455,282.0	(884,924.0)	90.5
	<b>Татварын өмнөх алдагдал</b>	мян.төг	<b>(10,924,554.0)</b>	<b>(12,346,404.0)</b>	<b>(565,600.0)</b>	<b>11,780,804.0</b>	<b>26.6</b>
4	ОАТ-ын зардал	мян.төг	-	-	(918,516.1)	(918,516.1)	-
5	<b>Цэвэр алдагдал</b>	мян.төг	<b>(10,924,554.0)</b>	<b>(12,346,404.0)</b>	<b>(1,484,116.1)</b>	<b>10,862,287.9</b>	<b>26.6</b>
6	Нийт ажиллагсдын тоо (үндсэн, гэрээт, ТУЗ)	хүн	95.0	121.0	96.0	(25.0)	79.3
7	Нийт цалингийн сан	мян.төг	2,728,746.0	3,087,454.0	2,713,223.0	(374,231.0)	87.9
8	Нэг ажилтны дундаж цалин	мян.төг	2,394.0	2,573.0	2,355.0	(218.0)	91.5
9	<b>Хөрөнгө оруулалт</b>	мян.төг	<b>3,469,865.0</b>	<b>342,599,341.0</b>	<b>292,998,476.0</b>	<b>(49,600,865.0)</b>	<b>85.5</b>
10	<b>Нийт авлага</b>	мян.төг	<b>4,678,148.0</b>	<b>3,537,906.0</b>	<b>1,223,063.0</b>	<b>(2,314,843.0)</b>	<b>3,027.3</b>
	Дансны болон бусад авлага	мян.төг	4,216,550.0	3,031,184.0	99,485.0	(2,931,699.0)	3,510.9
	Барьцааны авлага	мян.төг	47,520.0	22,255.0	47,520.0	25,265.0	213.5

Д/д	Үзүүлэлтүүд	Х/н	2022 оны гүйцэтгэл	2023 оны		Зөрүү	Хувь
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
	НДШ, татварын авлага	мян.төг	414,077.0	484,467.0	1,076,058.0	591,591.0	131.1
11	<b>Нийт өглөг</b>	мян.төг	<b>295,172,500.0</b>	<b>868,484,103.0</b>	<b>667,691,952.0</b>	<b>(200,792,151.0)</b>	<b>76.8</b>
	Дансны өглөг	мян.төг	64,111,883.0	591,908,028.0	390,658,342.0	(201,249,686.0)	66.0
	НДШ, Татварын өглөг	мян.төг	143,020.0	70,000.0	935,583.0	865,583.0	24.4
	Барьцааны өглөг	мян.төг	1,788,929.0	16,206,536.0	15,027,435.0	(1,179,101.0)	92.7
	Урт хугацаат зээлийн хүүгийн төлбөр	мян.төг	62,792,827.0	83,780,894.0	84,340,941.0	560,047.0	100.7
	Урт хугацаат зээл	мян.төг	166,335,840.0	176,518,645.0	176,729,651.0	211,006.0	100.1

#### Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой нийт 4,082.1 сая төгрөгийн 4 алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад 4,078.6 сая төгрөгийн 3 алдааг залруулж, 3.5 сая төгрөгийн 1 алдааг дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

#### Дараах алдааг залруулсан. Үүнд:

- Урьдчилж гарсан зардал дансыг бууруулж 2,719.1 сая төгрөгийн гадаад валютын ханшийн зөрүүний алдагдал нэмэгдүүлж бүртгэснийг залруулсан.
- Компани нь хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийг тооцоолж, бүртгэдэггүй байна. Гадаад валютаарх өр төлбөрийн ханшийн зөрүүний хэрэгжээгүй ашгаас үүссэн 918.5 сая төгрөгийг хойшлогдсон татварын өр болон хойшлогдсон татварын зардал дансдад бүртгэж залруулсан.
- Компани нь тоног төхөөрөмж авахтай холбоотой үүссэн хэрэгжээгүй НӨАТ-ын авлагын 441.0 сая төгрөгийг Хойшлогдсон татварын хөрөнгө дансанд бүртгэснийг дахин ангилж залруулсан.

Аудитаар нийт 518.5 сая төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 албан шаардлага хүргүүлсэн, 2 зөвлөмж өгсөн.

Аудитаар илэрсэн 6 зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 111.0 сая төгрөгөөс бага байгаа тул “Өөрчлөлтгүй” санал дүгнэлт өглөө.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

**Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Ханшийн тэгшитгэл буруу	1	2,719,118.3			1	2,719,118.3	1	2,719,118.3				
Хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөр бүртгээгүй	1	918,546.7	1	918,546.7			1	918,546.7				
Дансны ангилал буруу	1	441,020.4			1	441,020.4	1	441,020.4				
Орлого аккруэл сууриар бүртгээгүй	1	3,471.9			1	3,471.9			1	3,471.9	1	3,471.9
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>4,082,157.6</b>	<b>1</b>	<b>918,546.7</b>	<b>3</b>	<b>3,163,610.9</b>	<b>3</b>	<b>4,078,685.4</b>	<b>1</b>	<b>3,471.9</b>	<b>1</b>	<b>3,471.9</b>

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

Мянган төгрөгөөр

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
550 айлын хотхоны барилгын ажлын урьдчилгаанд 3 туслан гүйцэтгэгчид 3,937.2 сая төгрөгийн санхүүжилт олгосон ч гүйцэтгэл гараагүй, зээлийн хүүгийн зардалд 518.5 сая төгрөг тооцож алдагдлыг өсгөсөн. Өмнөх оны аудитаар тус зөрчлийг арилгуулахаар албан шаардлага хүргүүлснийг хэрэгжүүлээгүй байна.	1	518,545.7			1	518,545.7						
Нягтлан бодох бүртгэлийн орлого, зардал зохицох зарчмын дагуу тухайн цаг хугацаанд орлого олохтой холбоотой гарсан өртөг, зардлыг нягтлан бодох бүртгэлийн баримт бичигт тодорхой тусгаж, мөрдөж, ажиллах талаар өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.	1	-			1	-						

Төмөр зам ашиглуулсны орлого тооцох, бүртгэх процесст, мөн компанийн бүхий л үйл ажиллагаанд дотоод хяналтын мониторингийн үнэлгээ, эрсдлийн үнэлгээ, гэнэтийн хяналт гэх мэт дотоод хяналтын горимууд хийдэггүй байна.	1	-			1	-				
Компани нь үндсэн хөрөнгийн элэгдлээ татварын хуульд заасан хугацаагаар тооцдог байна.	1	-				1	-			
Ашиглаагүй биет бус хөрөнгөнд элэгдэл тооцсон.	1	-				1	-			
<b>Дүн</b>	<b>5</b>	<b>518,545.7</b>	-	-	<b>3</b>	<b>518,545.7</b>	<b>2</b>	-		

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

Зөрчлийн товч утга	Мянган төгрөг		Үүнээс			
	Нийт зөрчил		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<i>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</i>						
Мэдээлэл хугацаа хоцроосон	1	-			1	-
<i>Бусад хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</i>						
Компанийн ТУЗ нь 2023 оны 6 дугаар сарын 22-ний өдрийн 14 дүгээр тогтоолоор худалдан авалтын төлөвлөгөөг 572.8 сая төгрөгөөр баталсан байна. Төлөвлөгөө батлах ажил удааширч, 6 дугаар сарын сүүлд батлагдсанаас шалтгаалан 363.6 сая төгрөгийн худалдан авалт он дамжин хийгдэж, дараа оны худалдан авалтын төлөвлөгөөнд нөлөөлсөн байна	1	363,696.0			1	363,696.0
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>363,696.0</b>			<b>2</b>	<b>363,696.0</b>